


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

08.24 - 08.28



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Коронавирусийн вакцинтай холбоотой эерэг мэдээллүүд гарсантай холбоотой АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Эерэг мэдээтэй холбоотой эдийн засаг эргэн нээхэд хамгийн ихээр сэргэхээр хүлээгдэж буй агаарын тээвэр болон нисэх онгоцны үйлдвэрлэлийн компаниуд өсөлттэй байна.

Даваа гарагт Хүнс, Эмийн Захиргаа COVID-19 өвчтнүүдэд плазмын эмчилгээ хийхийг зөвшөөрсөн тухай мэдээлэл мөн АНУ-ын эрх баригчид AstraZeneca болон Оксфордын их сургуулийн хамтран боловсруулж буй вакциныг хурдан хугацаанд хянах талаар хэлэлцсэн нь агаарын тээврийн компаниудын хувьцааны үнийг огцом өсгөхөд хүргэсэн байна. Энэхүү мэдээ нь хөрөнгө оруулагчид агаарын тээврийн салбарыг сэргэх боломжтой гэж үзэхэд хүргэсэн ба АНУ-ын зарим агаарын тээврийн компаниуд өдөрт 10 орчим хувиар өссөн байна. Үүнтэй холбоотой Боинг болон түүний ханган нийлүүлэгчид компаниуд мөн өсөлт үзүүлсэн байна.

Европ: ХБНГУ болон Франц улсын эрх баригчид эдийн засгийг дэмжих нэмэлт арга хэмжээ авах болсон, АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хэсэгчилсэн хэлэлцээрийн сунгалт болон COVID-19-ийн эмчилгээтэй холбоотой эерэг мэдээ гарснаасүүдэн Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. STOXX Европ 600 индекс 1.02%-аар, Xetra DAX индекс 2.10%-аар, CAC 40 индекс 2.18%-аар, FTSE MIB индекс 0.74%-аар тус тус өссөн бол FTSE 100 индекс 0.60%-аар буурсан байна.

Коронавирусын халдварын хэмжээ эргэн нэмэгдэж байгаа хэдий ч Франц, Испани, Итали улсууд хөл хориог цуцлан цар тахлын хоёр дахь давалгааг урьдчилсан сэргийлэх арга хэмжээ аваагүй байна. Франц улсын Ерөнхий сайд Жан Кастекс хөл хорио тавихгүйн тулд шаардлагатай бүх арга хэмжээг авах болно гэж мэдэгдсэн боловч өнгөрсөн сард зарим бүс нутагт халдварын тоо дөрөв дахин нэмэгдсэнтэй холбоотой тус бүс нутгуудыг тусгаарлах шаардлагатай байгааг анхаарууллаа.

Япон: Энэ долоо хоногийн эхэнд Япон улсын хөрөнгийн зах зээл өсөлттэй байсан ч Баасан гарагт Ерөнхий сайд Шинзо Абэгийн огцорсон тухай мэдээ зах зээлд сөргөөр нөлөөллөө. Nikkei 225 индекс 0.16%-аар буюу 37 нэгжээр бууран 22,882.65 нэгж дээр хаагдлаа. Зах зээлийн үнэлгээ ихтэй компаниудын агуулдаг large-cap TOPIX индекс бага зэргийн өсөлттэй байсан бол зах зээлийн үнэлгээ багатай компаниудаас бүрдэх TOPIX Small индекс бага зэргийн уналттай хаагджээ.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт өсөлттэй байлаа. CSI 300 индекс 2.7%-аар өсөлттэй байсан бол Төрийн өмчит компаниудыг илүүтэйгээр агуулдаг Shanghai Composite индекс 0.7%-аар өсжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад БНХАУ-ын юаниар нэрлэгдсэн ханштай А төрлийн хувьцаануудын индекс 8.5%-аар өссөн S&P 500 индекстэй харьцуулахад 1.5%-аар илүү буюу 10%-аар өссөж дэлхийн хөрөнгийн зах зээлийн хамгийн их өсөлт үзүүлсэн индексүүдийн нэг боллоо.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	17,040.14	-0.10% ▼
Dow Jones	АНУ	28,653.87	2.59% ▲
S&P 500	АНУ	3,508.01	3.26% ▲
Nasdaq	АНУ	11,695.63	3.39% ▲
S&P/TSX	Канад	16,705.79	1.14% ▲
FTSE 100	Их Британи	5,963.57	-0.64% ▼
S&P/ASX 200	Австрали	6,073.80	-0.61% ▼
Nikkei 225	Япон	22,882.65	-0.16% ▼
Hang Seng	Хонг Конг	25,422.06	1.23% ▲

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	112.92
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	103.71
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	102.50
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	104.31
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	100.65
DBM' 2023	USD	7.250%	105.14
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	96.33

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.157	-0.10 ▼
Libor 3M	0.241	-0.04 ▼
Libor 6M	0.310	-0.01 ▼
Libor 1YR	0.445	0.01 ▲
US 2YR Bond	0.129	-0.10 ▼
US 3YR Bond	0.149	-0.08 ▼
US 5YR Bond	0.275	0.05 ▲
US 10YR Bond	0.731	0.17 ▲

Валютын ханш	2020.08.28	Өөрчлөлт
USD	2,852.83	0.07% ▲
CNY	415.42	0.71% ▲
EUR	3,392.59	0.52% ▲
RUB	38.17	-0.81% ▼
KRW	2.41	0.42% ▲
JPY	26.89	-0.48% ▼
CAD	2,179.06	0.76% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,964.83	1.25% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	27.50	2.66% ▲
Зэс	USD/lb.	301.95	2.91% ▲
Нүүрс	USD/MT	53.33	3.86% ▲
WTI газрын тос	USD/bbl.	42.97	1.49% ▲
Brent газрын тос	USD/bbl.	45.05	6.55% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.66	8.57% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.VII	3.40%
Бодлогын хүү	2020.VII	9.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.VII	8.85%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.VII	10.91%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.VII	4.24%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.VII	16.89%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.VII	10.45%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 53 компанийн 336.8 сая төгрөгийн 2,518,855 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Талх чихэр” /MSE: TCK/ компанийн хувьцаа 22.09%-аар буюу хамгийн ихээр өсөж 14,700.00 төгрөг хүрч хаагдсан бол “БиДиСек” /MSE: BDS/ компанийн хувьцаа 14.86%-аар буурч 716.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр “Лэндмн ББСБ” ХК-ийн 3.7 сая төгрөгийн 37 ширхэг үнэт цаас арилжаалагдав

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

8-р сарын 28-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,593.8 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 индекс 17,040.14 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.10% -аар буурсан байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	340.5	
Зах зээлийн үнэлгээ	2,593,778.8	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	17,040.14	-0.10% ▼
MSE I индекс	8,280.28	-0.42% ▼
MSE II индекс	7,382.43	0.60% ▲

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
АПУ	156,860	92,886,240
Говь	338,344	67,579,204
Ард даатгал	57,348	41,892,337
Мандал даатгал	813,534	34,917,302
Лэндмн ББСБ	664,944	20,618,291

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Талх чихэр	14,700.00	22.09% ▲
Улсын их дэлгүүр	1,399.00	16.48% ▲
Тээвэр-Ачлал	1,058.00	15.00% ▲
Э-Транс ложистикс	143.00	14.40% ▲
Хишиг уул	682.00	13.28% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
БиДиСек	716.00	-14.86% ▼
Дархан зочид буудал	125.00	-14.73% ▼
Материалимлекс	7,190.00	-14.40% ▼
Ард санхүүгийн нэгдэл	1,020.00	-9.73% ▼
Нако түлш	28.00	-6.66% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
БиДиСек	95,489,690
Гаүли	92,185,991
Ард Секюритиз	90,569,855
Бумбат-Алтай	89,042,344
Апекс Капитал	65,374,367

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	584.00	621,482.03
Таван толгой	6,060.00	319,151.11
МИК холдинг	12,800.00	265,079.30
Инвескор ББСБ	2,655.00	190,437.62
Говь	197.20	153,838.19

Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	LNBO-BD-19/06/21-C0008-17	37	3,700,280	100,020	100,010	52	17%

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-нд ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-нд ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-ны ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-нд ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-нд ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-нд ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-нд ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-ны ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БҮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-ны ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.08.06-нд ОЛГОВ
11	BUK	УЛААНБААТАР БҮК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.07.09-нд ОЛГОВ
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-ний ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-ны ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.07.30-нд ОЛГОВ
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-нд ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-нд ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-ний ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-ны ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.07.08-нд ОЛГОВ
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-нд ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-нд ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-ны ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.07.31-нд ОЛГОВ
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-нд ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-ны ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-ний ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.07.21-нд ОЛГОВ
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-ний ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-ний ДОТОР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 6-р сарын 10-ны өдрийн 340 тоот тогтоол болон холбогдох дүрэм, журмыг үндэслэн гаргасан “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 8-р сарын 24-ний өдрийн А/56 тоот тушаалаар “Ард менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулсан “Үндэсний хувьчлалын сан” хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50,000,000 ширхэг нэгж эрхийг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэлээ.

Ийнхүү олон улсын биржүүдэд түгээмэл арилжигддаг бүтээгдэхүүн манай зах зээлд цоо шинээр нэвтэрч байгаа нь хөрөнгө оруулагчид эрсдлээ тараан байршуулж, багц хувьцаанд хөрөнгө оруулах замаар хөрөнгө оруулалтын оновчтой удирдлагаар хангагдах бодит боломж бий болж байгаагийн зэрэгцээ дотоодын зах зээлд нэн шаардагдаж буй урт хугацааны мэргэжлийн хөрөнгө оруулагчдын бааз суурь бүрэлдэж буйгаараа онцгой ач холбогдолтой юм.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Анд-Энерги” /MSE: AND/ ХК-ийн 2019 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршууллаа.

“Анд-Энерги” /MSE: AND/ ХК-ийн 2019 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 1 төгрөг 08 мөнгө тараасныг 2020 оны 8-р сарын 24-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

Эх сурвалж: Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв



“Гермес центр” /MSE: HRM/ ХК хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараана.

“Гермес центр” /MSE: HRM/ ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 8-р сарын 24-ний өдрийн №14 тоот тогтоолоор 2020 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 6.6 төгрөг буюу нийт 518.4 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараахаар болов.

Энэхүү ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг 2020 оны 9-р сарын 9-ний өдрөөр гаргах бөгөөд 2020 оны 9-р сарын 15-ны өдөр “ҮЦТХТ” ТӨХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэв.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Бодь даатгал” /MSE: BODI/ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд.

“Бодь даатгал” /MSE: BODI/ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 7-р сарын 24-ний өдрийн № 20/04 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 9-р сарын 9-ний өдрийн 11:00 цагт хуралдуулахаар болсон тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурлын тов: 2020 оны 9-р сарын 9-ний өдрийн 11:00 цагт.

Хуралдах газар: Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу, 14201, Novotel зочид буудал 4 давхрын хурлын танхимд.

Бүртгэлийн өдөр: 2020 оны 8-р сарын 17-ны өдөр.

Хурлаар хэлэлцэх асуудал:

- 2020 оны хагас жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг тайлагнах;
- 2020 оны 2-р хагас жилийн бизнес төлөвлөлтийг танилцуулах
- Компанийн “Дүрэм”-ийн төслийг батлах;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөв батлах.

Холбоо барих утас: 70110280

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн 14 дэх дугаарыг Монголбанкнаас боловсруулан Та бүхэнд хүргэж байна. Уг тайлан нь (1) Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн эрсдэл эмзэг байдал, (2) Ковид-19 цар тахлын Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөлөл, (3) Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн салбарын голлох эрсдэл, эмзэг байдал, (4) Монголбанкнаас хэрэгжүүлж буй макро зохистой бодлогын арга хэмжээний тухай нийт дөрвөн бүлгээс бүрдэж байна.

Эх сурвалж: Монголбанк

МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2020 оны 7-р сард ажилгүй 5.2 мянган иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 1.3 мянган иргэн ажилд зуучлагдан орж, 5.4 мянган иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. Үүнээс Улаанбаатар хотод 2020 оны 7-р сард нийт 1.6 мянган иргэн нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 433 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

Улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд 1.1 (17.6%) мянган хүнээр, ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 0.3 (4.5%) мянган хүнээр буурчээ.

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэд 2020 оны 7-р сарын эцэст 28.1 мянга, үүнээс 18.0 (64.3%) мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 10.0 (35.7%) мянга нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 4.4 (19.5%) мянган хүнээр, өмнөх сараас 1.5 (7.7%) мянган хүнээр буурсан байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 9.3 (51.5%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 318 (1.8%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа бөгөөд 145 (45.6%) нь эмэгтэйчүүд байна.

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Манай улсаас БНХАУ руу хийж буй нүүрсний экспорт нэмэгдэж, 8-р сарын 25-ны байдлаар Гашуунсухайт, Шивээхүрэн, Ярант, Хангийн боомтоор нийт 2001 машин нүүрс экспортолжээ.

Энэ сарын 17-нд дээрх боомтуудаар 1809 машин гарч байсан бол өчигдөр ийнхүү 200 орчим машинаар нэмэгдэв. Сүүлийн 3 өдөр дараалан 1800-аас дээш машин нүүрс экспортолжээ. Гашуунсухайт, Шивээхүрэн, Ханги, Ярант боомтоор:

8-р сарын 17-нд 1809,

8-р сарын 18-нд 1838,

8-р сарын 19-нд 1844 машин нүүрс тус тус экспортолжээ.

Боомт тус бүрээр мэдээлбэл 8 дугаар сарын 19-нд Гашуунсухайтын боомтоор 1032, Шивээхүрэн боомтоор 730, Ярантаар 82 машин нүүрс, Гашуунсухайтын боомтоор 32 машин зэс тээвэрлэжээ.

“COVID-19”-ийн цар тахалтай холбоотойгоор манай улсын нүүрсний экспортыг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад энэ оны эхний 7 сарын байдлаар 46 хувиар буураад байсан юм. Тэгвэл энэ сараас эхлэн нүүрсний экспорт нэмэгдэж байна.

Хилээр гарч буй нүүрс болон бусад ашигт малтмалын тээврийн хэрэгсэл бүрийг ариутгал халдваргүйжүүлэлт хийн нэвтрүүлж байна. Импортын болон экспортын тээврийн ачааны автомашинуудыг бүрдүүлэлт хийх терминал руу цагдаагийн хамгаалалт дор шилжүүлэн хүргэж, хяналт шалгалт, бүрдүүлэлт, ариутгал халдваргүйжүүлэлт хийснээр хилээр нэвтрүүлж байна.

Эх сурвалж: Montsame.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.